

БАТЛАВ.
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАР-ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН
ДАРГА **Б.АРТУР**

2025 оны 09 сарын 16 ны өдөр

СУУРЬ БҮТЭЦ ХООРОНД СОЛИЛЦОХ, ДАМЖИН ӨНГӨРӨХ АЧААНЫ
ХЭМЖЭЭ ТОХИРОЛЦОХ ЭЭЛЖИТ ЗӨВЛӨГӨӨНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зөвлөгөөний зорилго

Суурь бүтэц хооронд солилцох, дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох ээлжит зөвлөгөөнөөр Төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах, нэгдсэн технологийн түр гормын хэрэгжилт, тээврийн хэмжээг тогтоох, тээвэрлэлтэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд оршино.

Хоёр. Хугацаа

Зөвлөгөөн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 08:00-17:00 цагт зохион байгуулагдана.

Гурав. Зохион байгуулагч байгууллага

Зохион байгуулагч: "Монголын төмөр зам" ТӨХК

Хамтран зохион байгуулагч: "Төмөр замын газар"

Дөрөв. Зөвлөгөөнд оролцогч байгууллага

1. Зам, тээврийн яам
2. Төмөр замын газар
3. "Монголын төмөр зам" ТӨХК
4. "Улаанбаатар төмөр зам" ХНН
5. "Монголиантранс Лайн" ХХК
6. "Монголиан Транс Ложистик" ХХК

Тав. Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудлууд

1. 2024 оны зөвлөгөөний шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэх
2. Төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах, нэгдсэн технологийн түр гормын хэрэгжилт
3. Төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд 2026 онд тээвэрлэх ачааны хэмжээг тохиролцох
4. Галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалт
5. Ачаа тээврийн ажлын зохион байгуулалт
6. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт
7. Бусад асуудал (тариф, төлбөр тооцоо, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр замын технологи ажиллагаа)
8. Дараагийн зөвлөгөөн зохион байгуулах хугацаа болон зохион байгуулах Төмөр замын байгууллагыг тохиролцох

Зургаа. Зөвлөгөөний ерөнхий зохион байгуулалт

1. Зөвлөгөөнийг Төмөр замын газар удирдаж, хөтөлбөрийн дагуу хурлыг зохион байгуулна.
2. Зөвлөгөөнд Төмөр замын суурь бүтэц эзэмшигч байгууллагын тээвэрлэлт, хөдлөх бүрэлдэхүүн хариуцсан замын орлогч дарга, газар, хэлтэс, албаны дарга болон холбогдох эрх бүхий удирдах албан тушаалтан, мэргэжилтнүүд оролцоно.
3. Зөвлөгөөн зохион байгуулахад Зам, тээврийн сайдын 2023 оны А/37 дугаар тушаалаар баталсан "Суурь бүтэц хооронд ачаа солилцох, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам", 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/328 дугаар тушаалаар баталсан "Төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах нэгдсэн технологийн түр горим"-ын биелэлт.
4. Суурь бүтэц хооронд тээвэрлэх ачааны хэмжээг хөрш орнуудын хилийн төмөр замуудтай солилцох тээврийн хүчин чадалд нийцүүлэн тохиролцоно.
5. Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудлыг холбогдох суурь бүтэц бүрээр бүлэгт хуваана. Бүлэг ахлах Төмөр замын байгууллага суурь бүтэц хооронд солилцох ачааны хэмжээ болон саналуудыг урьдчилан нэгтгэж, хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангасан байна.
6. Зөвлөгөөнд оролцох Төмөр замын суурь бүтэц эзэмшигч нар дэвшүүлсэн саналыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
7. Зөвлөгөөний протоколыг зохион байгуулагч байгууллага тэмдэглэж, зөвлөгөөнд оролцсон суурь бүтэц эзэмшигчийн ахлагч нараар гарын үсэг зуруулж, Төмөр замын газрын даргаар баталгаажуулна.
8. Төмөр замын суурь бүтэц эзэмшигчийг төлөөлөн оролцсон тохиолдолд гарын үсэг зурах итгэмжлэлтэй байна.

Долоо. Зөвлөгөөний бэлтгэл ажил

Зөвлөгөөн зохион байгуулагч нь зөвлөгөөн зохион байгуулахаас өмнө уг асуудлыг хэлэлцэх холбогдох суурь бүтэц эзэмшигч нарыг бүлэгт хуваасан байна.

Зөвлөгөөн зохион байгуулагч нь бүлгүүдийн ахлагч нараас суурь бүтэц бүрийн саналыг урьдчилан авч, нэгтгэн хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэсэн байна.

Найм. Зөвлөгөөний хөтөлбөр

Д/Д	Арга хэмжээ	Хугацаа
1	Бүртгэл	07:40 – 08:00
2	Төмөр замын газрын дарга Б.Артур нээж үг хэлнэ.	08:00 – 08:05
3	Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт үг хэлнэ.	08:05 – 08:10
4	Хурлын дэг, зохион байгуулалтыг Төмөр замын газрын Тээврийн удирдлагын газрын дарга М.Онон танилцуулна.	08:10 – 08:15
5	2024 оны зөвлөгөөний биелэлтийг танилцуулах /Төмөр замын газрын Тээврийн удирдлагын газар/	08:15 - 08:25
6	I бүлэг. Галт тэрэг, вагон солилцоо, ачааны хэмжээ тохиролцох ("Улаанбаатар төмөр зам" ХНН ахлана) "Монголын төмөр зам" ТӨХК – "Монголиан Транс Ложистик" ХХК – "Улаанбаатар төмөр зам" ХНН /Төмөртэй – Хандгайт – Ерөө/	08:25 – 09:10
7	Асуулт хариулт	09:10 – 09:25

8	Цайны завсарлага	09:25 – 09:40
9	II бүлэг: Галт тэрэг, вагон солилцоо, ачааны хэмжээ тохиролцох (“Монголын төмөр зам” ТӨХК ахлана) “Монголын төмөр зам” ТӨХК – “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголиантранс Лайн” /Хулангийн шанд – Зүүнбаян/	09:40 – 10:10
10	Асуулт хариулт	10:10 – 10:25
11	III бүлэг: Галт тэрэг, вагон солилцоо, ачааны хэмжээ тохиролцох (“Монголиантранс Лайн” ХХК ахлана) “Монголын төмөр зам” ТӨХК – “Монголиантранс лайн” ХХК /Цагаанцав - Номгон/	10:25 – 10:55
12	Асуулт хариулт	10:55 – 11:10
13	Галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалт, асуулт хариулт	11:10 – 12:00
14	Ачаа тээврийн ажлын зохион байгуулалт, асуулт хариулт	12:00 – 12:50
15	Үдийн зоог	12:50 – 14:00
16	Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, асуулт хариулт	14:00 – 14:50
17	Бусад асуудал (тариф, төлбөр тооцоо, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр замын технологи ажиллагаа)	14:50 – 15:20
18	Асуулт хариулт	15:20 – 15:40
19	Цайны завсарлага	15:40 – 15:55
20	Дараагийн зөвлөгөөний зохион байгуулалтын талаар зөвшилцөх	15:55 – 16:10
21	Зөвлөгөөнөөс гарсан санал, шийдвэр танилцуулах	16:10 – 16:30
22	Хурлын протоколд гарын үсэг зурж баталгаажуулах	16:30 – 16:55
23	Зөвлөгөөнийг хааж үг хэлэх /Төмөр замын газрын Тээврийн удирдлагын газрын дарга М.Онон/	16:55 – 17:00